



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 13 өдөр

Дугаар A/93

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1-10.4.5, 11 дүгээр зүйлийн 11.3.4, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлыг цуцлах хүртэлх хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.
2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт эрүүл мэндийн байгууллагын ажиллах горимыг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тушаалыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын дарга /Я.Амаржаргал/-д үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.


САЙД



Д.САРАНГЭРЭЛ

141200345

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн
Д/93 дугаар тушаалын хавсралт



ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ГОРИМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1-10.4.5, 11 дүгээр зүйлийн 11.3.4, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2020 оны “Удирдамж батлах тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор эрүүл мэндийн байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын горимд шилжүүлэн ажиллуулах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү горимыг үндэслэн тухайн орон нутаг, байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиг үүрэгт нийцүүлэн өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах төлөвлөгөө батлан, хэрэгжүүлж ажиллах бөгөөд энэ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр. Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

2.1. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн талаар байгууллагын ажилтан, албан хаагчдад танилцуулан, үүрэг чиглэл өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авна.

2.2. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед гарсан шийдвэр, үүрэг, чиглэлийг тухай бүр хэрэгжүүлж ажиллана.

2.3. Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах нөөц бүрдүүлэх, зарцуулах төлөвлөлтийг хийнэ.

2.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, эмнэлгийн ор дэлгэх, тусад нь эмнэлэг нээж ажиллуулах бэлтгэлийг хангана.

2.5. Байгууллага бүр бэлэн байдлын горимд ажиллах төлөвлөгөөндөө дараах үйл ажиллагааг нэмэлтээр тусган, баталж, мөрдөнө.

2.5.1. Үйлчлүүлэгч бүрийг угтан, халууныг нь хэмжиж, амны хаалт хэрэглүүлэх, сэжигтэй тохиолдлыг илрүүлж, зааврын дагуу ажиллана.

2.5.2. Байгууллагын дотоод хөдөлгөөний урсгалыг зохицуулж, эмчлүүлэгчийн сахиур, ар гэрийн эргэлтэд хязгаарлалт хийнэ.

2.5.3. Хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж ажиллана.

2.5.4. Шаардлагатай тохиолдолд энгийн хамгаалах хувцас, хэрэгсэл, амны хаалтыг бэлтгэх, нөөц бүрдүүлэхэд орон нутгийн Засаг дарга, нутгийн удирдлагын байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийг дайчлан, хамтран ажиллана.

2.5.5. Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах дадлага, сургалтыг зохион байгуулж, ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулна.

2.5.6. Ажилтан, албан хаагчдын ажил, үүргээ гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хоол хүнс, хувцас, техник хэрэгслээр хангах, аюулгүй ажиллагааг сахиулах, эрүүл мэндэд анхаарч ажиллана.

2.5.7. Байгууллагын ариун цэврийн өрөөний халдваргүйтгэлийг тогтмол хийж, үйлчлүүлэгчийн гараа угааж, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.5.8. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааг тогтмол хийж, зөвлөмж, сэрэмжлүүлгийг үйлчлүүлэгч бүрт түгээнэ.

2.6. Нөхцөл байдал болон удирдах шатны байгууллагын шийдвэрийг салбар нэгжийн удирдлага, ажилтан, албан хаагчдад тухай бүр мэдээлнэ.

2.7. Байгууллага, салбар, нэгжийн хэмжээнд ажиллах шуурхай штаб, эргүүл, жижүүрийг томилон удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

2.8. Нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Эрүүл мэндийн яаманд тухай бүрт шуурхай танилцуулна.

2.9. Бодит байдлын талаар орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж, буруу ташаа мэдээллийг тухай бүрт нь залруулна.

2.10. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байгаа тайланг долоо хоног бүрийн баасан гарагийн 17.30 цагаас өмнө Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт бичгээр болон цахимаар ирүүлнэ.

Гурав. Бусад

3.1. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллах үед хариуцсан ажилдаа идэвх зүтгэл гарган үр дүнтэй ажилласан ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулна.

3.2. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ, эрх, үүргийг зөрчсөн ажилтан, албан хаагчдыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.